



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2017.01.03 № 01

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Танд дараах агуулга бүхий асуулга тавьж байна.

Аливаа хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулан газрыг албадан чөлөөлөх буюу албадан нүүлгэн шилжүүлэх асуудал нь ихээхэн хурц үр дагавартай байдаг тул дэлхий нийтээр энэ асуудалд тодорхой бэлтгэлийг хангаж, болгоомжтой ханддаг нийтлэг жишиг тогтсон байна.

Монгол орны хувьд газар чөлөөлөхтэй холбоотой эрх зүйн орчин хангалтгүй байгаагийн уршгаар газрын эрхийн асуудлыг төр давамгайлан шийддэг, харин иргэд, байгууллагын албан болон албан бус эрхийг үл ойшоодог хандлага байсаар байна.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлж, гэр хорооллын оршин суугчдын эрүүл, аюулгүй, таатай амьдрах орчин нөхцөл болон газар ашиглалтыг сайжруулах, газрын үнэлгээг өсгөх зорилгоор инженерийн бэлтгэл ажил, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламж барихад зориулж иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшлийн газрыг дахин зохион байгуулах ажил хийгдэж эхэлснээс хойш нилээд хэдэн жил өнгөрч байна.

Дахин төлөвлөлтөд хамрагдсан айл өрхүүдээс товлосон хугацаандаа орон сууцандаа ороогүй, байр түрээслэх мөнгөө авч чадахгүй байгаагаас амьдрах газаргүй болсон, өр, зээл нь нэмэгдсэн, эрүүл мэндээрээ хохирч байгаа талаар иргэдээс гомдол, өргөдөл ихээр ирэх боллоо.

Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотойгоор дараах зүйлийг тодруулах шаардлагатай байна. Үүнд:

1. Гэр хорооллыг барилгажуулах асуудлыг үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа ажлын хүрээнд газрыг чөлөөлөхдөө зөвхөн “газрыг орон сууцаар солих” хувилбарыг сонгож байгаа нь иргэдийн хүсэл, сонирхолд тэр бүр нийцэхгүй байна. Иймд газрыг худалдан авах, хашаа, байшинг орон сууцаар солих зэрэг хуульд заасан бусад хэлбэрийг сонгохгүй байгаагийн учир нь юу вэ?

2. Орон сууцанд орохоор газраа чөлөөлсөн боловч, асуудал нь шийдвэрлэгдэх боломжгүй гацаанд орсон иргэдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж

байгаа, цаашид гэр хороололд амьдарч байгаа иргэдийг орон сууцаар хангах талаар ойрын хугацаанд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна вэ?


3.Барилга барих компаний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр бодлогын түвшинд ямар арга хэмжээ авах, барилгын компаниуд барьж буй барилга, орон сууцаа барьцаалан авч байгаа зээлийн хугацааг уртасгах талаар холбогдох талуудтай гэрээ хийж тохиролцох боломж байгаа эсэх;

4.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг боловсронгуй болгох шаардлага байгаа эсэх;

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд асуулгын хариуг бичгээр ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Д.СУМЪЯАБАЗАР

